

"МОНОС ХҮНС" ХК-ИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /маягт 1/

<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>		
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31 өдрийг хүртэл	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"МОНОС ХҮНС" ХК /MFC/ улсын бүртгэлийн дугаар 9010002005, регистрийн дугаар 5568927, утасны дугаар 7777-3525	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэр	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-д бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Онч аудит ХХК /2013-02-06/	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	408,850,429	
Жилийн тайланг бэлтгэсэн, хянасан албан тушаалтны нэр	Гүйцэтгэх захирал А.Отгондарь ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү	
1	Тайланг жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Орлогын тайлан	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	<p>Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хорооны 2026-02-09 болон 2026-02-13-ны өдрийн хурлаар компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон хөндлөнгийн аудитын компани "Онч аудит" ХХК-ийн дүгнэлт зэрэгтэй танилцан 2026-02-16 өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцүүлсэн. ТУЗ санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг нь олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэл, аудитын холбогдох хууль тогтоомж, дүрэм, эрх бүхий байгууллагаас гаргасан зохицуулалтын журмын заалтын дагуу үнэн зөв илэрхийлж тайлагнасан болохыг санал нэгтгэйгээр дүгнэн, дүгнэлтийг хүлээн зөвшөөрч 2026-04-15 өдөр хуралдахаар товлогдоод байгаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "ХЭЭХ" гэх)-д танилцуулахаар шийдвэрлэж ТУЗ-ийн 26/02 тогтоолоор баталгаажуулсан.</p>	
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловруулсан байх/	

	Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг Онч аудит ХХК хийсэн бөгөөд түүний дүгнэлтэд "Монос хүнс ХК-ийн 2025-12-31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ. Бид, дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн 2025-12-31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт- Нягтлан бодох бүртгэлийн стандартууд ("СТОУС -Нягтлан бодох бүртгэлийн стандартууд" гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.	
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Борлуулалтын орлого жилийн эцсийн байдлаар өнгөрсөн оноос 27%-иар өссөн. Цэвэр ашиг өнгөрсөн оноос 92% өссөн. Нийт ашгийн түвшин 50.5% Цэвэр ашгийн түвшин 16.1% Нийт хөрөнгийн өгөөж 12.7% Эздийн өмчийн өгөөж 26.1%
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нооц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа 1.3 Түргэн хөрвөх харьцаа 0.7 Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө 49% Өр төлбөр/Нийт хөрөнгө 51%
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Хотын зүүн бүсийн худалдан авагч нарт бүтээгдэхүүнийг түргэн шуурхай, зардал багатайгаар түгээлт хийх зорилгоор "East Log" буюу зүүн бүсийн агуулахын бүтээн байгуулалтын ажил 47% гүйцэтгэлтэй явж байна.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Тайлант хугацаанд зээлийн бүх эргэн төлөлтүүд хугацаандаа хийгдсэн. Авсан зээлийн дүн: 24.5 тэрбум Төлсөн зээлийн дүн: 29.4 тэрбум
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол, зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	2025 онд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийгдээгүй, 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл 1-ийг хийсэн. 2025 онд компанийн хэвийн үйл ажиллагааг явуулах үүднээс Монос хүнс ХК, түүний том хувьцаа эзэмшигч Л.Хүрэлбаатарын эзэмшлийн холбоо хамааралтай компаниудтай гэрээ хэлцэл хийхтэй холбоотой асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулж 2025-02-19-ны өдрийн 25/07 тоот тогтоолын хавсралтаар 25 компанитай хамтран ажиллах гэрээ хийх, гэрээнд зарын үсэг зурах эрхийг гүйцэтгэх удирдлагад өгсөн шийдвэрийг уг хэлцэлд хамааралгүй, сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэсэн.	
4	Цалин урамшууллын мэдээлэл	

	<p>Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.19.1, 7.19.2 заалт, "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын 8 дугаар зүйлд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тодорхойлох, урамшуулал олгох саналыг боловсруулах бүрэн эрхийг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо (цаашид "ЦУХ" гэх) хариуцаж байхаар тусгасны дагуу 2025-02-14-ны өдрийн ТУЗ-ийн дэргэдэх ЦУХ-ны хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээ, давтамж, ТУЗ-ийн 2025 оны төсөв зэргийг хэлэлцэж саналаа ТУЗ-ийн ээлжит хурал, ХЭЭХ-ын үеэр хувьцаа эзэмшигчдэд танилшуулан, ХЭЭХ-ын 2025-04-09 өдрийн 02 тоот тогтоолоор баталгаажуулсан. 2025-08-06 өдрийн 25/18 тоот ТУЗ-ийн тогтоолын 3-р хавсралтаар ТУЗ-ийн дэргэдэх ЦУХ-ы чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааг зохицуулсан бие даасан журмыг батлан, уг журамд КЭБАТ-ы цалин урамшууллын зохицуулалтыг тусгаж өгсөн. ТУЗ-ийн гишүүд сар бүр олгох тогтмол цалинтай, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүдийг хөдөлмөрийн гэрээ, онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээнд тусгасан дүнгээр үндсэн цалин, гүйцэтгэлээс хамаарсан урамшууллын цалин гэсэн үзүүлэлтээр дүгнэж байна. Компани 2025 онд нийт 12 тэрбум төгрөгийн цалин урамшууллыг ажилтнуудад олгосон, үүнээс 942 сая төгрөгийн цалин урамшууллыг ТУЗ-ийн гишүүд, ажлын алба, гүйцэтгэх захирал, санхүү хариуцсан захирал зэрэг эрх бүхий албан тушаалтанд олгосон байна.</p>
5	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>
	<p>2025-04-09 өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, хуралд саналын эрхтэй 306.7 сая ширхэг хувьцаа буюу 75.02%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцон, компанийн 2024 оны санхүү, үйл ажиллагааны тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт зэрэгтэй танилцан, ТУЗ-ийн 2025 оны төсөв, компанийн санхүү үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт зэргийг хэлэлцүүлэн хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.8%-ийн саналаар батлаж шийдвэрлүүлсэн. Хурлыг ТУЗ-ийн дарга Х.Ананд даргалж, ТУЗ-ийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн хуралдаа биеэр хүрэлцэн ирж, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулж, хурлаа амжилттай зохион байгууллаа. Хурлын шийдвэр тэмдэглэл холбогдох баримт бичгийг хуулийн хугацаанд зохицуулагч байгууллагууд руу хүргүүлэн хянуулсан.</p> <p>Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн ээлжит хурал улиралд 1 удаа, ээлжит бус хурлыг хуульд заасны дагуу тухайн үед зарлан хуралдуулдаг. 2025 онд ТУЗ ээлжит хурал 4, ээлжит бус хурал 5 удаа танхим, цахим, эчнээ санал хураалтын хэлбэрээр хуралдаж, нийт 27 тогтоол гаргасан. КТХ, СЗХ-оос баталсан Компанийн засаглалын кодексын 2-р зарчимд заасан ТУЗ хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс хороодын даргыг хараат бус гишүүнээр сонгож, хороодын бүрэлдэхүүнийг дийлэнх хувийг хараат бус гишүүдээс бүрдүүлж, их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл, хөрөнгө худалдах, худалдан авах, компанийн стратегийн шийдвэр гаргалт, эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал, томилгоо, сонгон шалгаруулалт зэрэг асуудлыг хорооны хурлаар заавал хэлэлцүүлж байж ТУЗ хуралд оруулан шийдвэрлүүлж байх, ингэснээрээ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргахад ТУЗ-ийн хараат бус гишүүдийн санал оролцоог голлож байхаар зохицуулалтын баримт бичгийг боловсруулан, томилгоо, бүрэлдэхүүнийг сонгон ажиллаж байна. 2025 онд ТУЗ-ийн дэргэдэх АЭХ 10 удаа, НДХ 5 удаа, ЦУХ 2 удаа, СБХХ 2 удаа хуралдсан байна.</p> <p>СЗХ-ы 145 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилтийн үнэлгээг 2025-05-31, 2025-12-31-ний өдрийн байдлаар гарган, өөрийн үнэлгээг хийж хянан баталгаажуулахаар нотлох баримтын хамт СЗХ-д хүргүүлсэн. КЗК-ын хэрэгжилтийн өөрийн үнэлгээ 96%. БОНЗ-ын болон Тогтвортой хөгжлийн тайлангаа гарган хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээлийн оролцогчдод мэдээлэл өгөхөөр МХБ-ийн цахим сайтад нээлттэйгээр байршуулаад байна. Мөн хугацаат болон бусад тайлан, шийдвэр мэдээллийг МХБ цахим сайт, өөрийн компанийн цахим сайтад тогтмол байршуулж байна.</p> <p>Монос хүнс ХК нь хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлагыг 6 жилийн турш тогтвортой хэрэгжүүлэн ажиллаж, хэрэглэгчиддээ хүргэх бүтээгдэхүүнийхээ чанар, стандартаа бататгасаар байгаа бөгөөд FSSC 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоо, ISO 9001 Чанарын менежментийн тогтолцооны стандартуудыг дэлхийд тэргүүлэгч Швейцарийн SGS компаниар 2025 оны 2 сард дахин баталгаажуулж, гэрчилгээний хугацаагаа амжилттай сунгасан.</p> <p>Улс орны бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлт, төсвийн орлогын бүрдүүлэлтэд бодитой хувь нэмэр оруулан, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэйгээр биелүүлж, татвараа шударгаар төлж байгааг төр засгаас өндрөөр үнэлж "Шийдэг татвар төлөгч" компаниар шалгаруулсан.</p>

	<p>Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 40 гаруй аж ахуйн нэгжээ тэргүүлэн “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг үйлдвэрлэгч” буюу “Топ 100 үйлдвэрлэгч”-ийн нэгээр шалгарч, хариуцлагатай үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, чанар, инновац, нийгмийн хариуцлагыг эрхэмлэн ажилласнаа өндрөөр үнэлүүлээ.</p> <p>Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зохион байгуулсан “Оны шилдэг аж ахуйн нэгж” шалгаруулах ёслолоос “Шилдэг үйлдвэрлэгч энтэрпренёр /хөнгөн үйлдвэрлэл/” шагналыг хүртлээ.</p> <p>Гүйцэтгэх захирал А.Отгондарь "Lady Entrepreneur 2025" шагнал гардуулах ёслолоос "Компанийн засаглал, нийгмийн хариуцлага, комплаенс хэрэгжүүлэгч энтэрпренёр хатагтай" хүндэт шагналыг гардан авсан. Тус шагнал нь компанийн засаглалыг оновчтой хэрэгжүүлж, бизнесийн ёс зүйг чандлан сахиж, нийгэмд эерэг өөрчлөлт авчирч буй эмэгтэй удирдагчдад олгодог хүндэтгэлтэй шагнал юм.</p>
6	Зэх зээлийн эрсдэлийн мэдээлэл
	<p>Монос Хүнс ХК нь тогтвортой өсөлт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор эрсдэлийг системтэйгээр илрүүлэх, үнэлэх, удирдах олон улсын шилдэг туршлагад нийцсэн аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Компанийн эрсдэлийн удирдлага нь 1. Эрсдэлийг илрүүлэх, 2. Эрсдэлийг үнэлэх, 3. Эрсдэлийг ангилах, 4. Хариу арга хэмжээг төлөвлөх, 5. Хэрэгжилтийг хангах, хяналт тавих гэсэн үндсэн үндсэн үе шаттайгаар хэрэгждэг. Энэхүү тогтолцоог хэрэгжүүлэх хүрээнд компанид: эрсдэлийн удирдлагын баг, дотоод аудитын тогтолцоо, "Annual Retreat" стратегийн арга хэмжээ зэрэг үндсэн хэрэгслүүдийг ашиглан эрсдэлийг тасралтгүй хянаж, сайжруулалт хийж байна.</p> <p>Компанийн хэмжээнд эрсдэлийг 1. Стратегийн эрсдэл, 2. Санхүүгийн эрсдэл, 3. Үйл ажиллагааны эрсдэл, 4. Нэр хүндийн эрсдэл, 5. Техник, технологийн эрсдэл, 6. Хууль эрх зүйн эрсдэл, 7. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэл, 8. Гадаад орчны эрсдэл гэж үндсэн ангиллаар тодорхойлсон.</p> <p>Эрсдэлийг нөлөөллийн түвшнээр нөлөө багатай, бага хэмжээний, анхаарал татахуйц, эрсдэлтэй, өндөр ноцтой хэмээн шатлалтайгаар үнэлж, эрэмбэлдэг.</p> <p>Илэрсэн эрсдэлүүдэд тохирсон дараах хариу арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд: 1. Эрсдэлээс зайлсхийх, 2. Эрсдэлийг бууруулах, 3. Эрсдэлийг шилжүүлэх (даатгал, гэрээг зохицуулалт), 4. Нөөц төлөвлөгөө боловсруулах, 5. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх зэрэг болно. Эдгээр арга хэмжээг алба, нэгжийн түвшинд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>2025 оны эрсдэлийн үнэлгээ: 2025 оны стратегийн "Annual Retreat" арга хэмжээний хүрээнд нийт 68 эрсдэл тодорхойлогдож, тус бүрд нь хариу арга хэмжээ боловсруулан холбогдох алба нэгжүүдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус арга хэмжээ нь байгууллагын стратегийн зорилтуудтай уялдан эрсдэлийн зураглал гаргах, нөөц бололцоог оновчтой хуваарилах, боломжийг эрт илрүүлэн ашиглах чухал ач холбогдолтой юм.</p>
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>"Монос хүнс" ХК нь хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Монголын Хөрөнгийн Биржид нээлттэйгээр арилжаалагддаг нийт 408,850,428 ширхэг хувьцаатай, 2012 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний үйлдвэрлэгч компанийн нэг юм. Нийт хувьцааны 70% буюу 286,195,300 ширхэг хувьцааг Л.Хүрэлбаатар (эцсийн өмчлөгч), үлдсэн 30% буюу 122,655,128 ширхэг хувьцааг олон нийт эзэмшдэг.</p> <p>Компанийн гухай хууль болон компанийн дүрэмд зааснаар компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд ээлжит хурлыг жилдээ 1 удаа хуульд заасны дагуу хуралдуулдаг. Компанийн 2024 оны санхүү үйл ажиллагаа хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 09 өдөр Баянгол дүүрэг, Сонсголонд байрлах өөрийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн байрандаа танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Хуралд нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 306,711,651 ширхэг хувьцаа буюу 75,02%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид танхим, цахимаар оролцсон тул хурлыг хуульд заасан хүчин төгөлдөрт тооцож хуралдуулан, хурлаар хэлэлцэх асуудлуудыг шийдвэрлэж тогтоол шийдвэрийг гаргасан. Хурлаас гарсан шийдвэр болон хурлын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг материалыг хуульд заасан хугацаанд Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлж ажилласан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг 2025-03-12 өдрөөр бүртгэхэд 15,462 болсон байна.</p>
8	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p>
	Тайланг өмнө тайлагнасан
9	Ногдол ангийн мэдээлэл

	<p>КТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалтад заасан бүрэн эрхийн хүрээнд ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 25/02 тоот тогтоолоор компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 37% буюу 1,635,401.712 төгрөг, нэгж хувьцаанд 4 төгрөгөөр тооцон ногдол ашиг тараах, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоож, ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөрт багтаан олгохоор шийдвэрлэсэн. Ногдол ашиг олгох мэдээллийг Монголын Хөрөнгийн Биржийн вэб хуудас, компанийн вэб хуудас, фэйсбүүк пэйж зэрэг цахим сувгуудад байршуулж, мэдээллийг түгээн ажилласан.</p>
10	<p>Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</p>
	<ol style="list-style-type: none"> 1. "Эрүүл мэндийн хүнсний үйлдвэр"-ийн үйл явц, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн талаар хөрөнгө оруулагч, олон нийтэд сурталчилан таниулах ажлын хүрээнд "MFC Tour" арга хэмжээг 2025 онд тогтмол зохион байгуулсан. 2025 оны 1 сард Үнэт цаасны компани, банк санхүүгийн байгууллагуудын төлөөлөл, конвениенс сүлжээ дэлгүүр "GS25" дэлгүүрийн ажилтнууд, 4 сард "Үй цай" сургуулийн сурагчид, 5 сард "Гурван тамир" сургуулийн сурагчид, АШУҮИС-ийн оюутны төлөөлөл, 6 сард Иогийн холбооны багш нар, 7 сард CNBC телевизийн ажилтнууд, 8 сард зах бөөний сувгийн харилцагчдын төлөөлөл, 11 сард "Хүнсний хувьсгал" үндэсний хөтөлбөрийн хүрээнд МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх тэргүүтэй төрийн ажилтнуудын төлөөлөл, 12 сард "American school" сургуулийн сурагчид, "BCN Knights" сагсан бөмбөгийн багийн тамирчид, мөн 2 сар тутамд зохион байгуулдаг Монос группын компаниудын шинээр ажилд орсон ажилтнуудын үйлдвэртэй танилцах аялал гэхчилэн нийт 900 гаруй хүүхэд, хүмүүст үйлдвэрээ танилцуулсан байна. 2. Нийгмийн хариуцлагатай кампанит ажлуудаа тайлагнаж, хамгийн сайн нөлөөлөл үзүүлсэн аян, үйл ажиллагаагаа танилцуулдаг "Social impact 2025" арга хэмжээнд "Хуванцарын хэрэглээг бууруулах замаар нийгэмд нөлөөлөх нь" сэдвийн хүрээнд хуванцарын хэрэглээг багасгаснаар байгальд ээлтэй шийдэл гаргаж байгаа ажлаа танилцуулсан. Мөн сэргээгдэх эрчим хүчийг ашигласнаар цахилгааны хэрэглээгээ 20%, саарал усны хэрэглээг нэмэгдүүлснээр усны хэрэглээгээ 10% тус тус бууруулан ногоон ирээдүйн төлөө хийж байгаа бодит алхмуудаа танилцуулан амжилттай оролцсон. 3. Эрүүл мэндийг дэмжигч компанийн хувьд залуу үеийг спортоор хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах зорилгоор сагсан бөмбөгийн "BCN Knights" баг, хөлбөмбөгийн "Hunters" баг зэрэг багуудтай 4 дэх жилдээ хамтран ажиллаж байна. Мөн 2025 оны 7 сард Монгол улсад зохион байгуулагдсан 30 гаруй орны 800 орчим жүдоч, дасгалжуулагчид оролцсон "Улаанбаатар Их Дуулга 2025" тэмцээний ивээн тэтгэгчээр оролцсон. 4. "Эх дэлхийгээ хайрлаж, эрүүл амьдралыг хамтдаа бүтээнэ" гэсэн алсын хараатай Монос Хүнс ХК нь Хан-Уул дүүргийн 14-р хорооны Түргэний аманд байрлах Рашаантын булагтын рашааны эхийг хашаалж, хамгааллаа. Рашаан нь газрын гүний эрдсийг шингээсэн байгалийн ундарга ус бөгөөд рашааны эхийг хамгаалах нь усны чанарыг хадгалах, байгалийн микро организм, ургамал, амьтны амьдрах орчны тогтвортой байдлыг дэмжих, цаашлаад байгалийн экосистем, хүний эрүүл мэндэд тустай учир хүний буруутай үйл ажиллагаа болон малын хөлөөс сэргийлж хашаалах ажлыг хийсэн. 5. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд идэвхтэй нэгдэж, "MFC Төгөл" байгуулсан бөгөөд Баянгол цэцэрлэгт хүрээлэнд мод тарих арга хэмжээг жилд хоёр удаа зохион байгуулж, энэ үйл ажиллагаанд компанийн ажилтнууд хүүхдүүдийн хамтаар идэвхтэй оролцон нийт 560 мод тариад байна. Мөн энэ цэцэрлэгт хүрээлэнгийн модны усалгааг үйлдвэрийн дахин цэвэршүүлсэн саарал усаар хангахаар ажиллаж байгаа нь байгальд ээлтэй үйлдвэрлэлийн нэг илрэл юм. 2026 онд 1000 мод тарихаар төлөвлөөд байна. 6. ХӨСҮТ-ийн Агаар дуслын халдварын тасагт "Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан эмчилгээний өрөө"-г тохижуулан хүлээлгэн өглөө. Энэхүү өрөө нь хүүхдүүд аав, ээж, асран хамгаалагчийнхаа хамт цагийг өнгөрүүлэх боломжтойгоор зохион байгуулагдсан бөгөөд зөвхөн эмчилгээний бус, сэтгэл санааг дэмжихэд чиглэсэн билээ. 7. Лантуун Дохио ТББ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Ид шидийн уут" сайн үйлсийн аянд нэгдэж, энэ жил 5,000 ширхэг витамин хандивлалаа. Манай компани 2015 оноос хойш энэ аянд нэгдэж, хамтран ажиллаж байгаа бөгөөд "Berryvit" брэндийн витаминг үрлээрээ дамжуулан мянга мянган бяцхан үрсийн дархлааг дэмжихэд хувь нэмрээ оруулсаар байна.

8. Эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл хүргэх зорилготой “Эрдэнэт хүн таны эрүүл биеийн төлөө” өдөрлөг, сургалтыг тогтмол зохион байгуулан хэвшээд байна. 2025 онд байгууллагын нийт 600 ажилтнуудыг хамарсан сургалтыг 12 удаа, Монос эмийн сантай хамтран 500 гаруй үйлчлүүлэгч, ажилтнуудыг хамарсан өдөрлөгийг 11 удаа, сувилалд амарч байгаа 400 гаруй сувилуулагчдыг хамарсан сургалтыг 3 удаа тус тус зохион байгуулж, нийгэмд түгээмэл тохиолдож буй өвчлөл, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн зөвлөгөө мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллалаа.

9. Монгол улсад анх удаа зохион байгуулагдаж байгаа Дундад Өргөргийн Бүсийн Орнуудын Хамтын Ажиллагааны олон улсын бага хурал, МУИС-ийн Инженер технологийн их сургууль, Баянгол дүүргийн 20 дугаар хороо, "Claim" Олон улсын байгууллага, Герентологийн үндэсний төв зэрэг байгууллагуудад өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хандив туслаж үзүүлэн хамтран ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

	Овог нэр: Агваандорж овогтой Отгондарь
	Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн Гүйцэтгэх захирал
	Гарын үсэг: (Тамга/тэмдэг)
	Овог, нэр: Нацаг овогтой Цагаанхүү
	Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
	Гарын үсэг: 



МОНОС
ХҮНС



FSSC 22000



2025 ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЖ ЭРҮҮЛ АМЬДРАЛЫГ ХАМТДАА БҮТЭЭНЭ.

VITOS
more health

ЦЭНЭГ



АГУУЛГА

1. БИДНИЙ ТУХАЙ	
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
Хэрэгжүүлж буй стандартууд	7
Түүхэн товчоо	8
Удирдлагын баг	10
2. 2025 ОНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ	11
Онцлох үйл явдлууд	12
3. ЭКСПОРТ БИЗНЕС ХӨГЖИЛ	15
Экспорт	16
Эрсдэлийн удирдлага	18
4. САНХҮҮГИЙН ТАЙЛАН	19
Санхүүгийн тайлан мэдээ	20
Голлох үзүүлэлтүүд	24
5. 2025 ОНЫ ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	27
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	28
Төлөөлөн Удирдах Зөвлөл	29
ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан	30
6. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ	31
Байгаль орчин, нийгэм, засаглал	32

БИЗНЕСИЙН ФИЛОСОФИ



АЛСЫН ХАРАА

Эх дэлхийгээ хайрлаж, эрүүл амьдралыг хамтдаа бүтээнэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүрээлэн буй орчин, оролцогч талуудаа хүндэлсэн, эрүүл амьдралын хэв маягийг дэлгэрүүлэгч, үнэ цэнэ бүтээгч хамт олон байна.



ҮНЭТ ЗҮЙЛС

ЭЭРЭГ СОЁЛ
ИННОВАЦЛАГ БҮТЭЭГДЭХҮҮН
ОРОЛЦОГЧ ТАЛУУД

1

БИДНИЙ ТУХАЙ



МОНОС ХҮНС ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ




Эрхэм хувьцаа эзэмшигчид, үнэт хэрэглэгчид, хамтран ажиллагсад та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монос Хүнс ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайланг танилцуулж байна.

Үйлдвэрийн өргөжилт тэлэлтийн төслөөс Логистикийн бүтээн байгуулалтруу шилжсэн хөрөнгө оруулалтын төслүүдтэй зэрэгцэн компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагааг жил ирэх тусам сайжруулж борлуулалтыг 27%, цэвэр ашиг 92%-иар тус тус өсгөж, эрүүл мэндийн хуурай болон шингэн хүнсний үйлдвэрүүд ч бүтээмжээ нэмэгдүүлэн ажиллажээ. Суурь судалгаа, зураг төсөл, барилга байгууламжийн бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт гээд 3 жил гаруй хугацаа шаардсан MFC 2.0 төслийн үр өгөөж гарч эхэлснийг хөрөнгө оруулагч та бүхэн санхүүгийн үр өгөөж, дүн шинжилгээнээс танилцах болов уу.

Цаашдаа бид Монгол оюун санааг дэлхийд таниулах экспортыг амжилттай эхлүүлэхийн тулд тухайн зах зээлд нь зориулсан эрүүл мэндийн судалгаа шинжилгээнд тулгуурласан бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг анхаарч, мөн компанийн дараагийн арван жилийн хөгжлийн дунд хугацааны стратегийг хэлэлцэж, хэрэгжүүлэхэд төвлөрч ажиллана.



Хүндэтгэсэн, А.Отгондарь
Гүйцэтгэх Захирал
Монос Хүнс ХК



Баталгаажсан стандартууд



FSC 22000

Хүнсний аюулгүй
байдлын тогтолцоо
FSC 22000



ISO 9001 : 2015

Чанарын удирдлагын
тогтолцоо
ISO 9001



ISO 14001

Байгаль орчны
чанарын удирдлагын
тогтолцоо ISO 14001



ISO 17025

ACCREDITED LABORATORY

Лабораторийн
итгэмжлэл
ISO 17025



ТҮҮХЭН ТОВЧОО

2012

Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, Монос Хүнс ХХК албан ёсоор үүсгэн байгуулагдав. Эрүүл мэндийн ус, ундааны цехийг ашиглалтад оруулав.



2013

Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.



2014

ODOO ERP /Enterprise Resource Planning/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.



2015

Монгол Улсад анх удаа эрүүл мэндийг дэмжсэн үйлдэлтэй Монголчуудын хооллолтын онцлог дээр тулгуурлан хүчил шүлтийн харьцааг тэнцвэржүүлэх Экос pH8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.



2016



Монгол Улсад анх удаа уусдаг цайны төрөлд импортыг орлох аньс, нэрс, чацаргана жимстэй өнгө үнэр амт орлуулагч ашиглаагүй Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.

2017



Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO 9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.

2018



Өтгөрүүлсэн Барагшун бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхлэв. Монос Хүнс компани биет бус хөрөнгөө үнэлүүлсэн Монголын анхны компани болов.

2019



Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO хийж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав.

ТҮҮХЭН ТОВЧОО

2020

Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо болох ISO 22000:2018 стандартыг нэвтрүүлэв. Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.



2021

Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.



2022

"Монос Хүнс" ХК нь Австри улсад төвтэй "TSC" /The chilled Snack Company/ компанийн ОХУ дахь салбар "TSC Food Products Ru" компанитай хамтран ажиллаж Милино брэндийн Творожное Драже үрлийг тус улсын зах зээлд амжилттай гаргалаа. Тус бүтээгдэхүүнийг Киргиз болон Евразийн 5 улсад гаргах боломж бүрдлээ.



2023



Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК, Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд анхаарал хандуулж "Хэнэгтэй Монгол Эр хүн" төслийг амжилттай эхлүүлж эрэгтэйчүүдийн тухай хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх нийгмийн нөлөөллийн төслийг амжилттай хэрэгжүүлж давхардсан тоогоор 22 сая хүнд хүргэж чадлаа.

Мөн 2023 онд Бүгд Найрамдах Киргиз улсын эм ханган нийлүүлэх Лекарь компаниар дамжуулан 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээ албан ёсны эрхтэйгээр тус улсад худалдан борлуулахаар боллоо.

2024



Монос Хүнс ХК 2024 онд MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслийг амжилттай хэрэгжүүлж, III улиралд ашиглалтад оруулснаар шингэн хүнсний үйлдвэрлэлийн хүчин чадлаа гурав дахин нэмэгдүүлж, бүтээгдэхүүний хүртээмж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүллээ. Бид үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо), FSSC 22000:2018 (Хүнсний аюулгүй байдал), ISO 14001:2015 (Байгаль орчны удирдлага) зэрэг олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлж, Швейцарын SGS компанийн аудитаар баталгаажууллаа.

2025 он

Монос Хүнс ХК 2025 онд үйлдвэрлэлийн хэмжээ 34%, борлуулалтын өсөлт өмнөх оны мөн үеэс 27% нэмэгдүүлэн ажилласан амжилттай байлаа. Мөн MFC East Log зүүн бүсийн агуулахын бүтээн байгуулалтын шавыг тавьж эхлүүллээ.



МОНОС ХҮНС ХК-ИЙН УДИРДЛАГЫН БАГ



А.ОТГОНДАРЬ
Гүйцэтгэх захирал



Ц.ДЭЛГЭРМАА
Санхүү хариуцсан захирал



Э.АМАРБОЛД
Маркетинг Борлуулалт
хариуцсан захирал



Б.БАЯНЖАРГАЛ
Үйлдвэрлэл хариуцсан
захирал



С. ЦЭРЭНПИЛ
Хуурай хүнсний
үйлдвэрийн дарга



Б. МӨНХЦЭЦЭГ
Чанар Баталгаажилтын
албаны дарга



Н.НАРАНБАТ
Борлуулалтын
албаны дарга



Б.ХУЛАНГОО
Чанар хяналтын
лабораторийн эрхлэгч



Ч.СЭЛЭНГЭТУЯА
Ложистикийн албаны дарга



Ц.ДӨЛГӨӨНМАЙДАР
Экспорт бизнес
хөгжлийн албаны дарга



П.УРАНЧИМЭГ
Шингэн хүнсний
үйлдвэрийн дарга



С.ГЭРЭЛСҮРЭН
Хангамж аж ахуйн
албаны дарга



Т.ЭНХЖИН
Маркетингийн албаны дарга



П.ЭНХБАЯР
Санхүүгийн менежер



Г.БУЯНДЭЛГЭР
Ерөнхий нягтлан бодогч



О.ЭРДЭНЭТУЯА
Хүний нөөцийн
ахлах менежер



В.ЭНХБАТ
ХАБЭА-н ахлах менежер



Ж.ЭНХМАА
Хуулийн зөвлөх

2

ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ

— Нэгдүгээр сар

MFC TOUR АРГА ХЭМЖЭЭГ АНХ УДАА ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монос Хүнс ХК нь “MFC Tour” арга хэмжээг зохион байгуулж эхэллээ. Энэхүү арга хэмжээний гол зорилго нь компанийн стратегийн чухал төсөл болох MFC 2.0 төслийн үр дүн, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шинэчлэл болон компанийн өдөр тутмын үйл ажиллагааны онцлогийг танилцуулахад чиглэсэн арга хэмжээ юм. Тухайлбал 2025 онд 300 гаруй зочид компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцлаа.

— Хоёрдугаар сар

EARNINGS CALL ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монос Хүнс ХК Earnings Call арга хэмжээг амжилттай зохион байгуулж, компанийн санхүүгийн үзүүлэлт, өсөлтийн стратеги болон цаашдын төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, шинжээчидтэй хуваалцлаа. Арга хэмжээний хүрээнд Үнэт цаасны компанийн төлөөлөл болох есөн компанийн 11 шинжээч оролцож, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөтэй холбоотой асуултуудыг удирдлагуудад тавьж, хариулт авлаа. Энэ нь олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд санхүүгийн үзүүлэлтүүд мэргэжлийн шинжээчидтэй шууд харилцсан нь хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлсэн ажил байлаа.

— Тавдугаар сар

МОНОС ХҮНС ХК “ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ” КОМПАНИАР ШАЛГАРЛАА



Монос Хүнс ХК нь улс орны бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлт, төсвийн орлогын бүрдүүлэлтэд бодитой хувь нэмэр оруулж буйг өндрөөр үнэлж, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны дунд сегментийн “Шилдэг татвар төлөгч” компаниар шалгарууллаа.

— Долдугаар сар

“МОНОС ХҮНС” ХК АВСТРАЛИЙН “LIFECYKEL” КОМПАНИТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА



Эрүүл мэндэд чиглэсэн 40 орчим бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд борлуулдаг Lifecykel компанийн толгой групп болох Mycelium Biotechnology группийн ТУЗ-ийн дарга William Scott Монгол улсад зочлон Монос Хүнс ХК-ийн үйлдвэртэй танилцаж бүтээгдэхүүнүүдийн амталгаа тэдгээрийн ашиг тус орц найрлагын талаар ярилцав.

Уулзалтаар Монос Хүнс ХК-ийн Өтгөн барагшун, Чацарганын цэвэр тос бүтээгдэхүүнүүдийг олон улсад худалдаалах хамтын ажиллагааны томоохон гэрээнд гарын үсэг зурлаа.

— Наймдугаар сар

МОНОС ХУНС ХК ГУРАВ ДАХЬ УДААГАА ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ЭМНЭЛГИЙН ОРЧНЫГ ТОХИЖУУЛЛАА



“Эрүүл амьдралыг хамтдаа бүтээнэ” төслийн хүрээнд Монос Хүнс ХК ХӨСҮТ-ийн Агаар дуслын халдварын тасагт “Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан эмчилгээний өрөө”-г тохижуулан хүлээлгэн өглөө. Энэхүү өрөө нь хүүхдүүд аав, ээж, асран хамгаалагчийнхаа хамт цагийг өнгөрүүлэх боломжтойгоор зохион байгуулагдсан бөгөөд зөвхөн эмчилгээний бус, сэтгэл санааг дэмжихэд чиглэсэн.

— Аравдугаар сар

МОНОС ХУНС ХК РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛЛАА



“Эх дэлхийгээ хайрлая” төслийн хүрээнд Монос Хүнс ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Хан-Уул дүүргийн 14-р хорооны Түргэний аманд байрлах Рашаантын булагтын рашааны эхийг хашаалж, хамгааллаа. Рашаан нь газрын гүний эрдсийг шингээсэн байгалийн ундарга ус бөгөөд байгалийн экосистем болоод хүний эрүүл мэндэд тустай. Тухайлбал рашааны эхийг хамгаалах нь усны чанарыг хадгалах, байгалийн микро организм, ургамал, амьтны амьдрах орчны тогтвортой байдлыг дэмжихэд чухлаар нөлөөлдөг. Хүний буруутай үйл ажиллагаа болон малын хөлөөс сэргийлж хашаалсан нь усны чанар алдагдах, эх ширгэх, бохирдох эрсдэлээс хамгаалах юм.

— Арваннэгдүгээр сар

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ “МОНОС ХУНС ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Монгол Улсын Хүнсний Манлай Үйлдвэр” Монос Хүнс ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцлаа.

Энэхүү уулзалт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан юм.

Монос Хүнс ХК нь уг хөтөлбөрийн хүрээнд 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан, “MFC 2.0 Нэгдсэн үйлдвэрийн төсөл”-ийг амжилттай хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтаа 6000 м.кв-аар өргөтгөөд зогсохгүй, MFC East Log зүүн бүсийн агуулахын бүтээн байгуулалтыг эхлүүлсэн. Үүний үр дүнд компанийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг гурав дахин нэмэгдүүлж, эх орны үржил шимт хөрсөнд ургасан эмийн ургамлын гаралтай түүхий эдээр бүтээсэн эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүнүүдийг дотоодын хэрэглэгчдэд тасралтгүй, тогтвортой нийлүүлэх боломжийг бүрдүүлээ.

— Арванхоёрдугаар сар

МОНОС ХҮНС ХК “ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧ ЭНТЕРПРЕНЁР” ШАГНАЛ ХҮРТЛЭЭ



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Оны шилдэг аж ахуйн нэгж” шалгаруулах ёслолоос Монос Хүнс ХК “Шилдэг үйлдвэрлэгч интерпренёр /хөнгөн үйлдвэрлэл/” шагналыг хүртлээ. Энэхүү шагнал нь компанийн 2025 онд хэрэгжүүлсэн бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн өсөлт, байгаль орчин нийгэм засаглалын чиглэлд гаргасан бодит үр дүнг үнэлэн урамшуулсан явдал байлаа.

МОНОС ХҮНС ХК “ТОП 100 ҮЙЛДВЭРЛЭГЧ” ШАГНАЛЫГ ХҮРТЛЭЭ



“Хүнсний ажилтнуудын өдөр-2025” баярын нэгдсэн арга хэмжээ 2025 оны 12 сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж, салбарын бодлого тодорхойлогчид, ахмад хүнсчид, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 40 гаруй аж ахуйн нэгжийн 320 гаруй төлөөлөл оролцлоо.

Энэхүү арга хэмжээний хүрээнд Монос Хүнс ХК “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг үйлдвэрлэгч” буюу “Топ 100 үйлдвэрлэгч”-ээр шалгарч, хариуцлагатай үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, чанар, инновац, нийгмийн хариуцлагыг эрхэмлэн ажилласнаа өндрөөр үнэлүүллээ.

3

ЭКСПОРТ БИЗНЕС
ХӨГЖИЛ





АНУ, Австрали

2025 онд олон улсын зах зээлд нэвтрэх стратегийн хүрээнд АНУ болон Австралийн зах зээлд хамтын ажиллагааг эхлүүлэх чиглэлээр тодорхой ахиц гаргасан.

АНУ-д төвтэй “Lifecykel LABS PTY” компанийн Австрали дахь салбар “Lifecykel” компанитай 2025 оны хоёрдугаар улиралд албан ёсны дистрибьютерийн гэрээ байгуулсан. Энэхүү гэрээ нь Монгол Улсад үйлдвэрлэсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд нэвтрүүлэхэд чухал алхам болсон.

Тус гэрээний хүрээнд:

“УВДИСТ” брэндийн “Өтгөн барагшун”, “Чацарганы цэвэр тос” зэрэг бүтээгдэхүүнийг харилцагчид зориулсан тусгай дизайн бүхий шошго, сав баглаа боодолтойгоор экспортлох бэлтгэл ажлыг ханган ажиллав.

Бүтээгдэхүүний шошго, найрлага, мэдээллийг олон улсын стандарт, тухайн улсын хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн боловсруулав.

Дээрх тусгай шошго, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дагуу 2025 оны гуравдугаар улиралд захиалга хүлээн авч, цаашдын экспортын бэлтгэлийг ханган ажиллав.



Бүтээгдэхүүний олон улсын баталгаажуулалт

Экспортын үйл ажиллагааг өргөжүүлэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд экспортын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг олон улсын итгэмжлэгдсэн лабораториудад шинжилгээнд хамруулсан. Тухайлбал:

“Өтгөн барагшун”, “Чацарганы цэвэр тос” зэрэг эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах лабораторийн шинжилгээг хийлгэж, тухайн 2 нэр төрлийн бүтээгдэхүүнүүдээр “Лабораторийн шинжилгээний тайлан” (Analytical Test Report) гаргуулсан.

Мөн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын хүрээнд АНУ-д гуравдагч этгээдийн (third-party) лабораторийн шинжилгээнд хамруулах дээж бүтээгдэхүүн илгээсэн.

Экспортын үйл ажиллагаанд шаардлагатай олон улсын стандартын шаардлагад нийцсэн сертификатуудыг бүрдүүлэн авсан. Үүнд: Биологийн идэвхт бүтээгдэхүүний гэрчилгээ болон U.S. Food and Drug Administration (FDA) буюу Хүнс, эмийн захиргааны байгууллагын шаардлагад нийцсэн бүртгэл, зөвшөөрлийн гэрчилгээ багтсан.

Эдгээр баталгаажуулалтын ажлууд нь манай бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг олон улсын түвшинд баталгаажуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, экспортын боломжийг өргөжүүлэх чухал үндэс болсон.


ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монос Хүнс ХК нь тогтвортой өсөлт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор эрсдэлийг системтэйгээр илрүүлэх, үнэлэх, удирдах олон улсын шилдэг туршлагад нийцсэн аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

2025 оны эрсдэлийн үнэлгээ


2025 оны стратегийн Annual Retreat арга хэмжээний хүрээнд нийт 68 эрсдэл тодорхойлогдож, тус бүрд нь хариу арга хэмжээ боловсруулан холбогдох алба нэгжүүдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус арга хэмжээ нь байгууллагын стратегийн зорилтуудтай уялдсан эрсдэлийн зураглал гаргах, нөөц бололцоог оновчтой хуваарилах, боломжийг эрт илрүүлэн ашиглах чухал ач холбогдолтой юм.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо



Энэхүү тогтолцоог хэрэгжүүлэх хүрээнд компанид **эрсдэлийн удирдлагын баг** болон **дотоод аудитын тогтолцоо** тогтмол ажиллаж буй юм. Мөн жил бүр Annual Retreat стратегийн арга хэмжээг зохион байгуулж эрсдэлийг тасралтгүй хянаж, сайжруулсаар байна.

Эрсдэлийн ангилал ба үнэлгээ



Эрсдэлийг нөлөөллийн түвшнээр



Эрсдэлийн хариу арга хэмжээ

Бид эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийг бууруулах, эрсдэлийг шилжүүлэх/даатгал гэрээт зохицуулалт/, нөөц төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх зэрэг хариу арга хэмжээг авч ажиллаж байна.

Эдгээр арга хэмжээг алба, нэгжийн түвшинд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж байна.

4

САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт /сая.төг/	2024 он Аудитлагдсан	2025 он Аудитлагдсан	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
				2024 он	2025он
ХӨРӨНГӨ	58,988.4	60,938.1	3%	100%	100%
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	17,569.7	16,489.9	7%	70%	73%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,292.4	53.2	-98%	4%	0%
Дансны авлага	5,196.9	6,915.3	33%	9%	11%
Татвар, НДШ - ийн авлага	43.7	364.1	733%	0%	1%
Бусад авлага	300.5	518.3	72%	1%	1%
Бараа материал	7,806.7	8,040.8	3%	13%	13%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	500.7	598.2	19%	1%	1%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	1,428.8	-	-	2%	0%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	41,418.7	44,448.2	-6%	30%	27%
Үндсэн хөрөнгө	38,214.9	41,963.9	10%	65%	69%
Биет бус хөрөнгө	327.1	298.1	-9%	1%	0%
Хойшлогдсон татварын хөрөнгө	95.2	62.9	-34%	0%	0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,781.5	2,123.3	-24%	5%	3%

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт /сая.төг/	2024 он Аудитлагдсан	2025 он Аудитлагдсан	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
				2024 он	2025 он
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	58,988.4	60,938.1	3%	100%	100%
ӨР ТӨЛБӨР	35,434.9	31,261.0	-12%	60%	51%
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,392.9	12,558.5	-35%	33%	21%
Дансны өглөг	1,621.1	1,359.4	-16%	3%	2%
Цалингийн өглөг	605.0	1,271.4	110%	1%	2%
Татварын өр	866.6	940.1	8%	1%	2%
НДШ-ийн өглөг	84.4	238.4	183%	0%	0%
Богино хугацаат зээл	14,625.1	7,105.0	-51%	25%	12%
Зээлийн хүүгийн өглөг	32.4	62.4	93%	0%	0%
Урьдчилж орсон орлого	93.7	130.7	40%	0%	0%
Нөөц өр төлбөр	231.0	270.2	17%	0%	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	1,233.8	1,180.9	-4%	2%	2%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,042.0	18,702.5	17%	27%	31%
Урт хугацаат зээл	13,507.4	17,333.2	28%	23%	28%
Нөөц өр төлбөр	2,467.6	1,266.8	-49%	4%	2%
Хойшлогдсон татварын өр	0.0	-	-	0%	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	67.0	102.5	53%	0%	0%
ЭЗДИЙН ӨМЧ	23,553.5	29,677.0	26%	40%	49%
Өмч - Хувьцаат	2,318.2	2,318.2	0%	4%	4%
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7	0%	12%	11%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	0%	0%
Хуримтлагдсан ашиг	14,399.6	20,523.1	43%	24%	34%

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН




Үзүүлэлт /сая.төг/	2024 он Аудитлагдсан	2025 он Аудитлагдсан	Өөрчлөлт %
Борлуулалтын орлого (цэвэр)	37,993.3	48,194.1	27%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	19,715.0	22,535.1	14%
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	18,278.2	25,659.0	40%
Түрээсийн орлого	-	2.5	-
Хүүний орлого	150.5	23.3	-85%
Бусад орлого	66.1	57.4	-13%
Борлуулалт, маркетингийн зардал	8,303.2	11,509.3	39%
Ерөнхий ба удирдлагын зардал	4,312.9	5,480.9	27%
Санхүүгийн зардал	1,022.9	2,105.1	106%
Бусад зардал	273.3	479.6	75%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(37.2)	(165.0)	344%
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	17.2	2,614.5	15115%
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	4,562.5	8,616.7	89%
Орлогын албан татвар	511.8	857.8	68%
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	4,050.7	7,758.9	92%

САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Үзүүлэлт	2024 он	2025 он
I. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ / LIQUIDITY RATIOS		
Эргэлтийн харьцаа / Current Ratio	0.9	1.3
Түргэн хөрвөх харьцаа / Quick Ratio	0.5	0.7
II. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ / LEVERAGE RATIOS		
Бие даалтын коэффициент / Shareholder Equity ratio	40%	49%
Өрийн харьцаа / Debt ratio	60%	51%
Өр эзний өмчийн харьцаа / Debt-to-Equity	150%	105%
Хөшүүргийн харьцаа / Debt-to-EBITDA	4.24	1.82
III. АШИГТ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ / PROFITABILITY RATIOS		
Нийт ашгийн хувь / Gross profit margin	45.7%	50.5%
ХТЭХӨАшгийн хувь / EBITDA margin	17.5%	27.9%
Цэвэр ашгийн хувь / Net income margin	10.7%	16.1%
Нийт хөрөнгийн өгөөж / Return on Assets - ROA	6.9%	12.7%
Өөрийн хөрөнгийн өгөөж / Return on Equity - ROE	17.2%	26.1%

ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жилээр



Улирлаар




ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд Монголын Хөрөнгийн биржийн арилжаагаар 286 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 954 сая ширхэг хувьцаа арилжсанаас Монос Хүнс ХК **10,769,419 ширхэг хувьцааг арилжиж, үнийн дүн нь 887,440,611 төгрөг, хувьцааны идэвхээр 13-д эрэмбэлэгдэж байна.**



ТАТВАР, НДШ-ИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 онд нийт 10.8 тэрбум төгрөгийн татвар, НДШ төлсөн бөгөөд үүнээс 8 тэрбум төгрөг нь татварт, 2.8 тэрбум төгрөг нь эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд төлөгджээ.





5

ТУЗ-ИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА



ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Х. Ананд

Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн дарга, Монос Группийн гүйцэтгэх захирал

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Монос Хүнс ХК нь эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэгч үндэсний үйлдвэрлэгчийн хувьд 16,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ итгэл, дэмжлэгт тулгуурлан 2025 онд хариуцлагатай засаглал, тогтвортой өсөлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлж ажиллалаа.

Талархал

Компанийн өнөөгийн амжилт нь удирдлага хамт олны нэгдмэл зорилго, үнэт зүйлс, тууштай хөдөлмөр, мөн хувьцаа эзэмшигчид, харилцагч, түнш байгууллагуудын итгэл, дэмжлэгийн бодит илэрхийлэл юм.

Бид цаашид ч эрүүл мэндийн хүнсний салбар дахь манлайлагчийн байр сууриа бататган, инновац, хариуцлагатай засаглал, тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурлан үнэ цэнийг бүтээсээр байх болно.

2025 оны гүйцэтгэлийн үнэлгээ

Компанийн хамт олны 2025 оны үйл ажиллагааны үр дүн, өсөлт амжилтад Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс өндрөөр үнэлж, амжилттай ажилласныг онцолж баяр хүргэж байгааг энд уламжлахад таатай байна. Тайлант хугацаанд бид:

Ил тод, хариуцлагатай засаглалын зарчмыг чанд мөрдөж, хувьцаа эзэмшигч, олон нийтэд бүх мэдээлж, шийдвэрээ хуулийн хүрээнд мэдээллэж тайлагнаж ажиллалаа.

Борлуулалт, ашигт ажиллагааны өсөлтийг хангаж, компанийн зах зээл дэх байр суурийг бататгалаа.

Ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, сургалт хөгжлийн хэрэгцээг анхаарч, ажлын орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулсаар байна.

Нийгмийн хариуцлагатай үндэсний үйлдвэрлэгчийн үүргээ нэр төртэй биелүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг бодит ажил хэрэг болголоо.

Стратегийн чиглэл

Бид хэрэглэгчдийн хэрэглээний зан төлөв, өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг урьдчилан тодорхойлж, дэвшилтэт техник, технологийн инновацыг тасралтгүй нэвтрүүлэхийн зэрэгцээ бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн стандартыг тогтмол сайжруулж байна.

Манай стратегийн зорилго нь зөвхөн богино хугацааны борлуулалтын өсөлтөд төвлөрөх бус, урт хугацаанд тогтвортой хөгжил, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэгдэж байна. Энэ хүрээнд засаглал, эрсдэлийн удирдлага, инновац, хүний нөөцийн хөгжлийг цогцоор нь авч үзэн бодлогын түвшинд хэрэгжүүлж байна.

Хүндэтгэсэн

Х.Ананд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Х.АНАНД
ТУЗ-ИЙН ДАРГА
Монос Групп Гүйцэтгэх захирал
ТУЗ-ийн дэргэдэх ЦУХ-ны дарга



Л.ХҮРЭЛБААТАР
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Групп үүсгэн
байгуулагч, Монгол Улсын
Хөдөлмөрийн баатар, Академич



А.ОТГОНДАРЬ
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Хүнс ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Х.СОЛОНГО
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Групп Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



М.САРАНДАВАА
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Повер солюшн ХХК
Гүйцэтгэх захирал



Ц.ЦЭЦЭГБАДАМ
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Групп Санхүү
эрхэлсэн захирал



Г.ЗОЛЖАРГАЛ
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Ашид Ассет менежмент
ҮЦК ХХК Гүйцэтгэх захирал,
ТУЗ-ийн дэргэдэх АЭХ-ны дарга



Д.ЭНХЖАРГАЛ
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Судлаач
ТУЗ-ийн дэргэдэх НДХ-ны дарга



Д.ГЭРЭЛТ-ОД
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Контент Маркетинг ХХК
Гүйцэтгэх захирал,
ТУЗ-ийн дэргэдэх СБХХ-ны дарга



Н.УЛААНХҮҮ
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Эдийн засагч



Б.БАТ-УУЛ
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Сэнд Эм Эн ББСБ ХХК-ийн
Технологи хариуцсан захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Тайлангийн хугацаанд Монос Хүнс ХК-ийн ТУЗ нь ердийн 6, хараат бус 5, нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллажээ. Энэ хугацаанд ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Баттогтох өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, компанийн тухай хуульд зааснаар хараат бус гишүүний шаардлагыг хангасан ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос /НДХ/ нээлттэйгээр зарласнаар 63 хүний хүсэлт, анкетад тулгуурлан ТУЗ-ийн дэргэдэх НДХ эхний, 2025 оны 11-р сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар эцсийн сонгон шалгаруулалтыг тус тус хийн ТУЗ-ийн гишүүнийг түр орлох гишүүнээр Б.Бат-Уулыг томилсон байна.

ТУЗ-ийн хурал

2025 онд Монос Хүнс ХК-ийн ТУЗ нь ээлжит хурал 4 удаа, ээлжит бус хурал 5 удаа хийхдээ танхимаар 4, цахимаар 3, эчнээ санал хураалтаар 2 удаа тус тус зохион байгуулж, эдгээр хурлаар нийт 35 асуудлыг хэлэлцэн, 27 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд Гүйцэтгэх захирал, удирдлагын багийн ажилтнуудад 40 үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллав.

2025 оны ТУЗ-ийн онцлох шийдвэрүүд

2025 оны 2-р сарын 19-ны ээлжит хурлаар компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт, ногдол ашиг хуваарилах асуудал, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов, мөн “Шүгэл үлээх журам”-ыг хэлэлцэн, холбогдох тогтоол, шийдвэрийг гаргав. 2025 оны 8-р сарын 7-ны ээлжит хурлаар Гүйцэтгэх удирдлагаас танилцуулсан Улаанбаатар хотын зүүн үйлдвэрийн бүсэд хэрэгжүүлэх “MFC EAST LOG” төслийн хөрөнгө оруулалтыг дэмжиж шийдвэрлэв. Оны эцсийн байдлаар төслийн хэрэгжилт 38%-тай байгаа бөгөөд 2026 оны эхний хагас жилд багтаан төслийг ашиглалтанд оруулахаар төлөвлөн төслийн баг ажиллаж байна. Мөн тус хурлаар ТУЗ-ийн дэргэдэх хороодын бие даасан журмыг хэлэлцүүлж тогтоолоор батлав.



A large, white, stylized number '6' is positioned in the upper left quadrant of the page. The background is a gradient of teal and light blue. A series of white, curved lines sweep across the right side of the page, creating a sense of motion and depth. The overall aesthetic is clean and modern.

6

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ

2025 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БАЙГАЛЬ ОРЧИН:

1.01 л

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан усны хэмжээ

16%

Усны зохистой хэрэглээг бүрдүүлж, нэгж бүтээгдэхүүнд ногдох усны зарцуулалтыг өмнөх оноос 16%-иар бууруулаа.

15%

Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг бүрдүүлж 15%-ийн хэмнэлт хийв.

23%

Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэв.

22%

Дахин ашигласан саарал усны хэмжээ

154 тонн

Экос зөөлөн усны хуванцарын хэмжээг 30%-иар бууруулснаар 154 тонн хуванцарын хог хаягдал байгальд үүсэхээс сэргийлэв.

НИЙГЭМ:

59%

Эмэгтэй удирдах ажилтан

190
САЯ

2025 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 27%-ийг ногдол ашиг болгон хуваарилав.

230

Цагийн сургалт

2104

Сургалтад хамрагдсан ажилтны тоо

617

ХАБЭА сургалтад хамрагдсан ажилтны тоо

4

Үйлдвэрийн осол

ЭДИЙН ЗАСАГ:

7,9

ТЭРБУМ

Төлсөн татвар шимтгэл

27%

2025 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 27%-ийг ногдол ашиг болгон хуваарилав.

25,4

ТЭРБУМ

Сүүлийн 5н жилийн төлсөн татварын шимтгэл

4,9

ТЭРБУМ

Дотоодын худалдан авалт

ЗАСАГЛАЛ:

55%

ТУЗ-ын эрэгтэй гишүүдийн эзлэх хувь

45%

ТУЗ-ын хараат бус гишүүдийн эзлэх хувь

0

Авилга, хээл хахуулийн зөрчил

96%

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ

ХҮНИЙ НӨӨЦ БА ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

НИЙТ АЖИЛТАН **267**

ЭРЭГТЭЙ
157

ЭМЭГТЭЙ
110

УДИРДАХ АЖИЛТАН **17**
ҮҮНЭЭС ЭМЭГТЭЙ **10**

ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
АЖИЛТНЫ ТОО **7**

BABY BOOMERS

2024 2.7%
2025 2.6%

GEN X

2024 17.6%
2025 15.4%

MILLENNIAL

2024 60.7%
2025 51.7%

GEN Z

2024 28.2%
2025 30.3%

АЖИЛТНЫ
СЭТГЭЛ
ХАНАМЖ

2024 **78.2%**

2025 **77.2%**

▼ 1%

АЖИЛТНЫ
ЭНГЭЙЖМЕНТ

2024 **77.3%**

2025 **77.4%**

▲ 0.1%

ДУНДАЖ АЖИЛЛАСАН ЖИЛ **3.7 ЖИЛ**

ЭКО
УУСДАГ ЦАЙ



Амархан уусах юм аа...

ЭКО
УУСДАГ ЦАЙ



ТӨВ ОФФИС:

Сонсголонгийн зам гудамж 32/3 тоот,
Үйлдвэрийн баруун бүс, БГД, 20-р хороо,
Улаанбаатар, 16103, Монгол Улс

МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТЫН АЛБА:

Эко Интернэйшнл тауэр 19 давхар 1908
тоот, СБД, Нэгдүгээр хороо, Улаанбаатар,
Монгол Улс



www.monosfoods.mn



Foods@monos.mn



MonosFoods



976-7777-3525